

НИЙСЛЭЛИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН

УЛААНБААТАР ХОТЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ, 2030 ОНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

**Улаанбаатарын бүсийн түүх, соёлын дурсгал, амралт аялал жуулчлалыг
2020 он хүртэл төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага**



❖ Удирдах хэсэг

Нэр	Албан тушаал	Эрдмийн цол, зэрэг
Л.Солонго	НЗТХ. Хэлтсийн дарга	Архитектурын магистр
М.Билэгсайхан	МУИС. ГГС. АЖТ	Доктор, дэд профессор
Б.Байгаль	НЗТХ. Хэлтсийн архитектор	-

❖ Оролцож ажилласан

Нэр	Албан тушаал	Эрдмийн цол, зэрэг
Х.Цогбадрал	МУБИС. ГГС. АЖТ	Газарзүйн ухааны магистр
Ө.Амгалан	МУБИС. ГГС. АЖТ	Түүхийн ухааны магистр
Д.Энхжаргал	МУИС. ГГС. АЖТ	Газарзүйн ухааны магистр
С.Амаржаргал	МУИС. ГГС. АЖТ	Газарзүйн ухааны магистр
Э.Цоморлиг	МУИС. ГГС. АЖТ	Бизнесийн удирдлагын магистр
Н.Гантуяа	МУИС. ГГС. АЖТ	Байгалийн ухааны магистр
Б.Солонго	МУИС. ГГС. АЖТ	Газарзүйн ухааны магистр
Э.Оюунцэлмэг	МУИС. ГГС. АЖТ	Байгалийн ухааны магистр



АГУУЛГА

ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРАГ, ХҮСНЭГТ, ХАВСРАЛТ	5
1. ТАНИЛЦУУЛГА	6
1.1. ӨМНӨТГӨЛ	6
1.2. ҮНДЭСЛЭЛ	7
1.3. ЗОРИЛТ	7
1.4. ЗОРИЛГО БА ХАМРАХ ХҮРЭЭ	7
2. АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН ОДООГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ	9
2.1. САЛБАРЫН ТОЙМ ҮЗҮҮЛЭЛТ	9
2.2. ТҮҮХ, СОЁЛЫН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛT	10
2.3. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	13
2.4. ЭКОЛОГИЙН АЯЛАЛ	24
2.5. ХОТЫН АЯЛАЛ	26
2.6. ХҮҮХЭД, ЗАЛУУСЫН АЯЛАЛ	27
2.7. ӨМНӨХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	28
3. АМРАЛТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН 2021-2030 ОНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	31
3.1. УЛААНБААТАР ХОТОД	32
3.2. НИЙСЛЭЛИЙН БҮСЭД	38
3.3. ТАТАЛЦЛЫН БҮСЭД	39
3.4. ҮР ДҮН	41
4. АМРАЛТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН 2012-2020 ОНЫ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ	42
4.1. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД	42
4.2. УЛААНБААТАР ХОТОД	46
4.3. НИЙСЛЭЛИЙН БҮСЭД	54
4.4. ТАТАЛЦЛЫН БҮСЭД	58
4.5. ҮР ДҮН	59



5. АШИГЛАСАН МАТЕРИАЛ61

ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

АЖТХТ	Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БНГ	Байгалийн нөөц газар
БЦГ	Байгалийн цогцолбор газар
ДЦГ	Дархан цаазат газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИС	Монгол улсын их сургууль
МҮЭ	Монголын үйлдвэрчний эвлэл
МХЗҮТ	Монголын хүүхэд залуучуудын үндэсний төв
НАЖГ	Нийслэлийн аялал жуулчлалын газар
НАЖМТ	Нийслэлийн аялал жуулчлалын мэдээллийн төв
НБГ	Нийслэлийн боловсролын газар
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
НЗТХ	Нийслэлийн зураг төслийн хүрээлэн
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НОӨГ	Нийслэлийн оюуны өмчийн газар
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
УБС	Улаанбаатар сан
ХАҮТ	Худалдаа, аж үйлдвэрийн танхим
ХЗЯ	Хууль зүйн яам



ЗУРАГ, ХҮСНЭГТ, ХАВСРАЛТ

Зураг

Зураг № 1. Улаанбаатарын бүсийн аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 2. Эрчимтэй таталцлын орон зайн аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 3. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 4. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 5. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 6. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 7. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 8. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 9. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 10. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Зураг № 11. Байгалийн амралт, аялал жуулчлын нутаг дэвсгэрийн бүсчлэл

Зураг № 12. Улаанбаатар хот - 2030

Зураг № 13. Улаанбаатар бүс - 2030

Зураг № 14. Бүсийн эрчимтэй таталцлын хүрээ - 2030

Зураг № 15. Улаанбаатар хот - 2020

Зураг № 16. Улаанбаатар бүс - 2020

Зураг № 17. Бүсийн эрчимтэй таталцлын хүрээ - 2020

Зураг № 18. Хотын аяллын маршрут - 2020

Хүснэгт

Хүснэгт № 1. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Хүснэгт № 2. Аялал жуулчлалын нөөцийн байршил

Хүснэгт № 3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн 2006 – 2015 оны төлөвлөлтийн хэрэгжилтийн байдал



1. ТАНИЛЦУУЛГА

1.1. ӨМНӨТГӨЛ

XVIII ьóóíú ýõýí çåýñ Ëõ õçðýú õóààèääà, àðèèæààíú çàõ çýýèèéí òíííõíí ò°à áíèæ óèñ õííðííäúí, íðíí íòðàèéí +àíàðòàé àðèèæàà, óèñ ò°ð, ýàèéí çàñàèéí òàðèèõààíú òòèäóóð төв болох эхлэл тавигдсан түүхтэй. Нийслэлийн àìðàèò, àýèàè æóóè+èàèúí ò°ãæил нь Улаанбаатар хот, хот орчмын эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшилтэй уялдан хөгжлийн шинэ шатандаа шилжих үйл явц өрнөж байна. Сóóðèí àæ ò°ð°õ хэв маяг ççññýí çåýñ Óèààíáààðòàð õíòúí иргэдийн àìðàèò, àýèàè æóóè+èàèúí хэрэгцээг хангах ажил үйлчилгээ үүсэж иржээ.

Өнөөдөр Нийслэл, нийслэлийн ойр орчимд од зэрэглэлтэй зочид буудлын 90, тур операторын 95, жуулчны баазын 60, хүүхдийн зуслангийн 50 орчим хувь байрлаж, гадаадын жуулчдын 90 орчим хувь Улаанбаатараар дамжин өнгөрч байна.

Европын хотожсон орнуудад үндэсний амралт, аялал жуулчлалын 60-70 хувь нь хотын аялал байдаг бол Улаанбаатарт албан ажил, боловсрол, эрүүл мэнд, арилжааны шинжтэй аялал, спорт, соёл урлагийн арга хэмжээ, зугаацал, зочид буудал, зоог ундаа, зугаацлын ажил үйлчилгээ төвлөрч байна. Нийслэл, Ò°à àéíгийн хүн амын механик болон ердийн өсөлтийн сацуу Улаанбаатар хотын улс төр, эдийн засаг, нийгмийн хурдацтай хөгжлийг дагаж гадаад, дотоодын гийчдийн òíí óèàì íýíýääýõ òàíäèääà àæèèääääõ áíèíâ.

Нийгмийн чиг баримжаатай эдийн засгийн үр өгөөжтэй үндэсний амралт, аялал жуулчлалын зангилаа бүс болгон хөгжүүлэхэд дотоодын амралт, аялал жуулчлалд хандсан бүтээгдэхүүний нэр төрөл, үйлчилгээний чанарыг эрс сайжруулах орчин нөхцлийг бүрдүүлэхэд төр захиргаа, хувийн хэвшлийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааны тулгуур баримт бичиг болох ерөнхий төлөвлөгөөг эргэн харах хэрэгцээ нэгэнт үүсэв.



1.2. ҮНДЭСЛЭЛ^{1,2}

- I. “Монголын ард түмний өвөрмөц соёл, зан заншил, өв уламжлалыг сэргээн дээдэлж, хүн төрөлхтний бүтээсэн эрдэм соёлын үнэт зүйлсийг биширч, хувь хүний оюун санааны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангаж чадахуйц нийгмийн орчин бүрдүүлэх”,
- II. “Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ”,
- III. “Байгалийн унаган төрхийг хадгалан даацад нь нийцүүлэн аялал жуулчлал хөгжүүлэх, менежментийг нь боловсронгуй болгох”
- IV. “Импорт орлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих”
- V. “Хөгжлийн боломж бүрийг дайчлан ашиглаж, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, улмаар жилд ирэх жуулчдын тоо хүн амын тоотой тэнцэнэ”, 2007-2015 онд “монголд ирэх жуулчдын тоог нэг саяд хүргэх”,
- VI. “Бүх төрлийн үйлчилгээний стандартуудыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах”

1.3. ЗОРИЛТ^{3,4}

“Идүүагэ гæеёиёиёе оудуаоууяа оёёёднii оуауяа оiд о+дооёабагэ а°а°а iāiāeēi оудуаоууяа iēeöyö õ°āæeēēā” баримтлан “гадаад, дотоодын жуулчдын сохирхолыг татсан нүүдэлчдийн аялал жуулчлалын төв хот” болгон хөгжүүлэх дэс дараалсан арга хэмжээг уялдан зохицуулах баримт бичиг боловсруулахад оршино.

1.4. ЗОРИЛГО БА ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго:

- I. Улаанбаатарын хотын амралт, аялал жуулчлалын өнөөгийн байдлыг тодорхойлох,
- II. Улаанбаатарын хотын амралт, аялал жуулчлалын хөгжлийн 2021-2030 оны чиг хандлагыг төсөөлөх,
- III. Улаанбаатарын хотын амралт, аялал жуулчлалын 2012-2020 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгох,

¹Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр МХ-21. 45-р тал.

² Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. 2008 он. 41-р тал.

³Оiāoāiđoie õ°āæeē. MNS ISO 14050:2003

⁴ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 05 дугаар сарын 25-ний өдрийн 45 тоот тогтоол



Төлөвлөлтийн үндсэн зарчмууд:

- I. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эрх зүйн харилцаатай амралт, аялал жуулчлалын бүтээгдэхүүнээр нийслэлийн иргэд, дотоод гадаадын гийчдийн хэрэгцээг хангах,
- II. Шинэ технологи, оновчтой арга хэрэгсэлийг ашиглан байгаль, соёлын өвийн хамгаалалтыг сайжруулах,
- III. Амралт, чөлөөт цаг, аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, нийслэлийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх.

Хүлээж буй үр дүн:

- I. Байгаль, түүх, соёлын дурсгалт зүйлсийн ашиглалтын менежмент зохистой болж, үндэсний амралт, аяллын бүтээгдэхүүний үнэлэмж нэмэгдэнэ.
- II. Дотоодын амралт, аялал жуулчлалын орчин нөхцөл сайжирч, гадаадад аялах урсгал саарч, аялал жуулчлалын бизнесийн улирлын хамаарал буурна.
- III. Зорчигч тээвэр, байр сууц, музей үйлчилгээ, спорт, нийтийн зугаацлын дэд бүтцэд сонирхогч талуудын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
- IV. Аялал жуулчлалын чөлөөт бүсээр дамжин зүүн хойд азийн аялал жуулчлалын зах зээлд гарна.



байгуулалт, урсгал, даацын талаарх эдийн засгийн тоо баримт байдаг ч бүгд эргэлзээ төрүүлдэг тул баримжаалсан байдлаар ашиглагдаж байна. Амралт, аялал жуулчлалын үзэгдэл, үйл явцын үнэн зөв, бодит мэдээлэл нь оновчтой бодлого боловсруулах, ажиглалт, зохицуулалт хийх, арга хэмжээг төлөвлөх, хөрөнгө оруулалт татах нэг чухал хөшүүрэг болж байна. Статистик мэдээллийн хомсдол эсвэл эргэлзээтэй арга зүйгээс үүдэн амралт, аялал жуулчлалын зах зээлийн мониторинг, эдийн засгийн үр өгөөж, алдагдлын хэмжээ бүрэн төгс гарч ирдэггүй учраас эрсдлийг тооцоолох аргагүй болдог. Энэ нь хөрөнгө оруулалтын эрсдлийг дагуулж байна. Иймээс уул уурхай, хөдөө аж ахуй, мал аж ахуй, үйлчилгээний салбар зэрэг тэргүүлэх хэдэн салбарын статистик мэдээллийн системийг эргэн харж, талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.2. ТҮҮХ, СОЁЛЫН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Түүх соёлын үл хөдлөх өв нь аялал жуулчлалын чухал нөөц юм. Улаанбаатар орчимд Туул голын ай саваар 252⁵, Улаанбаатарт 205⁶ эртний болон орчин цагийн түүх соёлын дурсгалууд бүртгэгджээ. Улаанбаатарын бүсийн ойр орчимд XIX зуунд хамаарах 6, 1930 – 1939 онд хамаарах 1, 1940 – 1949 онд хамаарах 5, 1950 – 1959 онд хамаарах 8, 1960 – 1969 онд хамаарах 13, 1970 – 1979 онд хамаарах 6, 1980 – 1989 онд хамаарах 19, 1990 – 1999 онд хамаарах 35, 2000 оноос хойш 12 ширхэг байна.⁷ Улаанбаатар хотод түүх, соёлын дурсгалаар 176 нэрийн өв бүртгэгдснээс үзвэл 43 буюу 24.4 хувь нь уран сэтгэмжтэй баримал дурсгал, 45 буюу 25.6 хувь нь хувь хүний дүрс баримал, 31 буюу 17.6 хувь нь бэлэгдлийн дурсгал, 21 буюу 17.6 хувь нь барилга, 7 буюу 4.0 хувь нь булш, буурь, 29 буюу 16.5 хувь нь өндөрлөг, хаалга зэрэг биет дурсгал гэсэн ангилалд хамрагдаж байна. 1899 оноос өмнө бүтээгдсэн дурсгал 10.2 хувь, 1900-1999 онд 47.8 хувь, 2000 оноос хойш 42.0 хувийг эзэлж байна. Улс, аймаг, сум, дүүргийн хамгаалалтад бүртгэлтэй түүх, соёлын үл хөдлөх үнэт зүйлсийг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар олон хөтөлбөрт дурьдсан хэдий ч чухам ямар арга замаар ашиглах нь тодорхойгүй хэвээр байна. Улаанбаатар хотын газар зохион байгуулалтын алдаатай *áíäëíäúí óðøääàð ñçéòäýääñýí*, хувьд шилжүүлсэн, үндсэн хийцэд нөлөөлөх үйл ажиллагаа явуулан *ýääýðñýí*, нураагдсан түүхэн *áàðëëää áäéäóóëäíæëëä áäéääë* цөөнгүй бий.

Оёääáíáääòàð òíòúí 2020 он хүртэлх *áð°íõëé ò°ë°äë°ä°íä òóñääääcàí òççõ-àððëòäêòóðúí äóðñääëúí 10 öíäöíëáíð* нь *óýñýä+ëëñýí áð°íõëé ò°ë°äë°ä°íä ääðääæ, òäíäääëäëòúí áçñ, îð+ëí òíéðíú áàðëëääæëëòúí äíðëíüä òíäòíò, öíäöíëáíðò áäéäää áàðëëäóóäüä ñýðäýýí çññääðëäж аялал жуулчлалын эргэлтэд îðóóëäð øààðäëääàðäé* хэмээн төлөвлөсөн байдаг. Үүнд:

- *Äàíääääðæää òëéä;*
- *Äàíääì òëéä;*
- **íéæëí èàìúí ñçì;*
- *Áíääüí íñäíí îðäíí;*

⁵Х.Лхагвасүрэн. 2009 он.
⁶ А.Цэрэнчулуун. 2011 он.
⁷ Г.Баатарцоож. 2009 он.



фасад, явган зорчих хэсэг, гэрэлтүүлгийг барилга уран сайхны цогц шийдлээр шинэчлэн засварлаж, автобусны зогсоолыг хязгаарлах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүний зэрэгцээ Улаанбаатарын имижийг Хотын төвийн нийтийн орон сууцны фасадын өнгө үзэмжийг сэргээн засварлах, хот, бүс, таталцын орон зайн түүх соёлын үл хөдлөх өв, соёлын дурсгалын бүртгэлийг шинэчлэн тоолох зэрэг цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Соёлын өвийг хамгаалах хуулийн 17 дугаар зүйлийн 6, 7 дугаар заалтын хэрэгжилтийг хангах ба Засгийн газрын 2001 оны 96 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн нутаг дэвсгэр дээр орших улсын хамгаалалтад байдаг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Гандантэгчилэн хийд, Гэсэр сүм, Богд хааны ногоон ордон, Чойжин ламын сүм, Дамбадаржаалин хийд, Дашчойлин хийд, Чин ван Ханддоржийн байшингийн хамгаалалтын бүсэд шинээр барилга бариулахгүй ба хамгаалалтын бүсэд баригдсан барилгыг буулгах шаардлагатай. Хавсралт № 1.

Амралт, аялал жуулчлалд бодит хөрөнгө оруулалт үргэлж дутагдаж байдаг. Тухайлбал, Засгийн газрын 2010 оны 146 дугаар тогтоолоор Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн менежментийг төрийн бус байгууллагаас аялал жуулчлалын үндэсний төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар шилжүүлж, арчилгаа үйлчилгээг хариуцуулсан юм. Байгууламж 201.2 сая төгрөгийн төсөвтэй бөгөөд гүйцэтгэлийн ажил хөрөнгө мөнгөний хомсдлоос болж удааширч байна. Өнөөдрийн байдлаар усан мандлын ажилд 19.6, цэцэрлэгжүүлэх, мод тарих ажилд 154.0, жуулчны мэдээллийн цэгийн ажилд 13.7, бэлэг дурсгалын асарт 1.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу хийгдсэн байна.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”⁸-ийг 2007 онд баталсан ба дараах үр дүнд хүрнэ хэмээн төлөвлөж байжээ. Үүнд:

- Улс, аймгийн хамгаалалтад байдаг түүх, соёлын үл хөдлөх есөн дурсгалыг бэхжүүлж, зургаан дурсгалыг сэргээн засварласан байна,
- Түүх, соёлын үл хөдлөх дөрвөн дурсгалын хэв, дардсыг авч соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалсан байна,
- Аялал жуулчлалын чиглэл, бүс нутагт байгаа түүх, соёлын хорин үл хөдлөх дурсгал, нэг маягийн танилцуулга-самбартай болсон байна,
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд аялал жуулчлалын чиглэлд орж аялал жуулчлалын бүтээгдэхүүн нэмэгдсэн байна,
- Соёлын өвийг хамгаалах, сурталчлах талаар бүх насны хүмүүст зориулсан баримтат кино бүтээж, танилцуулга, гарын авлага бэлтгэсэн байна,
- Улаанбаатар хотод “Үлэг гүрвэлийн музей” байгуулсан байна,
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээний үндсэн дээр эзэмшүүлж хамгаалсан байна зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн атал хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар албан ёсны мэдээ тайлан хийгдээгүй байна.

⁸Монгол улсын засгийн газрын тогтоол. 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр. Дугаар 303. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”.




судалгаагаар тогтоогдов.⁹ Зураг №1, 2. Хотын хүн амын сүүлийн жилүүдийн хэт өсөлт нь зоог ундаа, зочид буудал, амралтын газар, тээврийн хэрэгсэл, дээд боловсролын байгууллагын тоог эрс нэмэгдүүлэв. Харин хотын иргэдийн нийгмийн аялал жуулчлал, гадаадын иргэдийн соёлын болон бизнес аяллын хэрэгцээ шаардлагыг хангахуйц хүүхдийн зуслан, олон улсын зэрэглэлийн зочид буудал, нийтийн амралт, зугаалгын үйлчилгээний байгууламж, музей, байгалийн аялал жуулчлалтай холбоотой ажил, үйлчилгээ төдийлөн нэмэгдсэнгүй. Ажил үйлчилгээ, дэд бүтцийн талаар жуулчдад үлдсэн сайн муу сэтгэгдэл нь Улаанбаатар хот улмаар Монгол улсын аялал жуулчлалын нэр хүндийг дагуулж байна. Бизнес эрхлэгчид амралт, аялал жуулчлалын цогцолбор, зам, онгоцны буудал, нисэх онгоц зэрэг томоохон хөрөнгө оруулалт шаардах төсөлд оролцох боломж хомс, байсан ч санхүүгийн бэрхшээлээс болж төсөл санаачлага удааширч, төлөвлөсөн түвшингийн гүйцэтгэл гардахгүй байна. Энэ нь Улаанбаатарын бүсийн амралт, аялал жуулчлалын олон улсад өрсөлдөх чадварыг сулруулдаг нэг хүчин зүйл болж байна.

⁹ Нийслэлийн зураг төслийн хүрээлэн. 2010 он.



èðñýí. Ñàíàè àñóóèää ìðíèõíññàí 43.0 õóâü íü 3-5 àìðàèòüí ààçàð, 36.0 õóâü íü 1-2, 18.0 õóâü íü 5-10, 3.0 õóâü íü 10-ààñ íèíí àìðàèòüí ààçàð íýäýæ áàéääà íü òíðòííàñíí áàéääà. Õìììíèéí í÷èõ äóðòàé ààçàð íü ààðààð áàéääààð æàññààæýý. Çóðàà ¹ 10.

Çóðàà ¹ 10. Ñóàèääàíà òàìðàññàí òìììíèéí í÷èõ äóðòàé ÷èèýè



Õììíýàð ¹ 2. Àìðàèòüí ààçòüà ñííñííà òàèäóóð

Òàèäóóð ççççèýèò	Ýð	Ýí
÷èè÷èèäýý	9.5	10.3
÷íý	14.3	13.8
Áàéääàèèéí áàéääàè	28.6	31.0
Àìðàèòüí ààçòüí òíðèæèèèò	9.5	27.6
Áàèð ñóóóíü òíðü òóð	9.5	6.9
Õííèíü ààçòüí çèè÷èèäýý	14.3	3.5
Íýíýèò çèè÷èèäýý	14.3	6.9
Äçí	100	100

Àìðàà÷èä àìðàèòüí ààçòüà ýìàð òàèäóóðààð ñííñííà áàéääàà ñííèðòíðíà 1. Áàéääàèèéí áàéääèüà 28.6-31.0 õóâü, 2. Àìðàèòüí ààçòüí òíðèæèèèòüà 9.5-27.6 õóâü, 3. ÷íèèä 13.8-14.3 õóâü èèççä ççæýý. Õììíýàð ¹ 11. Ýíäýýñ ýðýàðýè, ýíýàðýè àèü àèü íü áàéääàèèéí áàéääèüà èèçç ÷òðàè÷èèæ áàéääà íü òàðàààà.

Õìò ìð÷ííí àìðàèòüí çèè÷èèäýýèè áàéäóóèèääóóà íèä òçøèèýí áàèðèàð íü òçäýýíýè áàéíà. Íèä í÷ííí òìììíýýñ ààññàí ñóàèääààààð æèíñ, ¹⁰⁰à, ýíèéí óðààìàè òççäýä 22.0 õóâü, òçèýý òççäýä 18.0 õóâü, áèàèéí òç÷ òàìèðàà ñýðäýýæ àèæààè òàéèääà 26.0 õóâü, áàéääàèèéí ñàèõíüà òàðæ, àíí ççéí òààðààè ààààà 26.0 õóâü áóñàà òýèäýýýð àðèèèääàà 8.0 õóâü áàéíà.¹⁶ Ñýèäý àíèüí òííèèéí ýðýýð Ëò Áäýí (2033 í), Õíðèò (1706 í) äýñýí Áààà Õýíðèéí ñàèàð òóèñ ìðøèò á¹⁰⁰à çàì òàðèèèàà,

¹⁶ Á.Äýèäýð æàðààè, Á.Õýíñçèýí. Õèààíààòàð òìò ìð÷ííí íñííí äçíèéí íéí òàèðàààèè àðèèèèèè. Áàíèíàè ààçàðççéí ñàèààðüí çàèèò ýðäýíðàèéí òíèèí. ÝØÁ. ÓÁ.2003.80-ð òàè.



2.4. ЭКОЛОГИЙН АЯЛАЛ


2011 онд Монгол улс байгаль орны тогтвортой байдлын зэрэглэлээр 139 орноос 138-д¹⁷ жагсаж байгаа нь байгаль хамгаалах үйлсэд амралт, аялал жуулчлалыг хамгаалалтыг хэрэгсэл болгон ашиглах бодлого боловсруулахад хүргэж байна. Байгалийн өвийг хадгалаж биш харин гоо сайхны хүмүүжлээр дамжуулан хамгаалах бүхий л арга замыг дэлхий даяар эрэлхийх болов. Эко жуулчлал бол хөгжиж буй орны аялал жуулчлалын хөгжлийн нэг боломж аяаааааа нийтээр хүлээн зөвшөөрөв. Бааааааа орчны бохирдолтой хийх тэмцлийг үргэлжлүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авахад байгалийн амралт, аялал жуулчлалыг эдийн засгийн үндсэн хөшүүргээр дэмжихийн тулд ТХГН-ийн аялал жуулчлалын үйл ажиллагааг бодлогоор зохицуулах шаардлага байна. Ялангуяа нийслэл болон таталцлын орон зайд орших зуслангийн бүс, Хан Хэнтийн дархан цаазат газар, Горхи-Тэрэлж, Хустайн байгалийн цогцолборт газар, Тэрэлж хороо, Эрдэнэ сумын I багийн туул голын сумын тусгай хамгаалалттай хэсэг, Гачуурт, Улиастайн голын эрэг хөвөөгөөр голын эргийн хураамж, барилга байгууламжийн эзэлхүүний хураамж, хүчин чадлын хураамжаар хязгаарлалтын горим тогтоох зэрэг шийдвэртэй цогц арга хэмжээ авах цаг тулгараад байна. Хан хэнтий, Горхи-Тэрэлж, Богд хан, Их баян, Баянзүрх, Сонгино хайрханы байгалийн явган болон морин аяллын баталгаажсан замнал тогтоож, отоглох, аялагчдын аюулгүй байдлыг хангах зэрэг зохион байгуулалтын нэгдсэн журам боловсруулж хатуу чанд мөрдүүлэх зохицуулалт үгүйлэгдэж байна. Улаанбаатар хот нь Богд хан уул, Сонгино хайрхан уул, Чингэлтэй хайрхан уул, Баян зүрх хайрхан уул зэрэг Хэнтийн салбар уулсын хооронд, Туул, Гачуурт, Улиастай, Сэлбэ голын ая саваар ногоон байгууламж байгуулж амралт, аяллын нөхцөл нөөцийг бүрдүүлэх ажлын эхлэлүүд гарч байна. Сэлбэ, Толгойт, Улиастай, Гачуурт, Хуандий, Дэндий, Богд уулын амууд анх амралт, гэр бүлийн зуны зуслангийн зориулалтаар ашиглаж байсан бол одоо байнгын суурьшил бүхий нутаг дэвсгэр болж байна. Жил ирэх тутам орон зай тэлсээр байгаа нь нийслэлийн ногоон бүсийн, голын эх орчмын байгаль, экологийн асуудлыг хүндрүүлэх болов.

Иймээс гэр бүлийн зуслангийн ногоон бүсийн суурьшил, аж ахуйн үйл ажиллагаа, хамгаалалтыг зохицуулах “Нийслэлийн ногоон бүс”-ийн тухай эдийн засгийн зохицуулалт бүхий хууль боловсруулж мөрдөх шаардлага үүсэв. Түүнчлэн гадаад, дотоодын иргэдийн байгалийн амралт, аяллын орон зайгаар Горхи орчмын нутаг дэвсгэр ашиглагдсаар ирсэн ч даац хэтэрч байгалийн амралтын бүс гэдэг утгаа алдаж байна. Энэхүү орон зай Улаанбаатар хотын байгалийн амралт, аялал жуулчлалд тэргүүлэх байр суурь эзэлж байгаа тул экологийн амралт, аялал жуулчлалын бүс болгох эрх зүйн акт гаргаж, экологийн жуулчлалын хууль боловсруулж хязгаарлалт хийж хойч үедээ энэ хэвээр үлдээх нь одоо үеийхний нэг том үүрэг юм.

¹⁷ 2011 World Economic Forum. The Travel & Tourism Competitiveness Report 2011. P-304



Зураг № 11. Байгалийн амралт, аялал жуулчлын нутаг дэвсгэрийн бүсчлэл





нэгдсэн зохион байгуулалттай тээврийн байнгын үйлчилгээ зах зээлд хараахан гарч ирээгүй байна. Хот, хот орчимд зөвхөн нэг чиглэлээр дагнасан аялал нь явцгүй учир хүүхэд, залуучууд, дотоод, гадаадын иргэд зэрэг боломжит зах зээлд хандсан соёл-түүх-байгаль-ахуйн чиглэлийн нөөцүүдийг хамруулсан автобус аяллыг түгээн дэлгэрүүлэх нь хотын аяллыг шинэ шатанд гаргах нэг арга зам юм.

Хот газар, суурь дэд бүтцийн бүтээн байгуулалт, хүн амын нягтшил зэрэг давуу талаа ашиглан өндөр боловсрол төлөвшилтэй оршин суугчид, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг татах гарцыг сайтар судлах шаардлага тулгарч байна. Хот өөрөө аяллын бүтээгдэхүүн гэдэг үзэл баримтлалыг дэлгэрүүлж, хотын аяллын уриа, бэлэг тэмдэгийн зэрэгцээ Нийслэлийн аялал жуулчлалын ялгарах дүр төрхийг Нью-Йорк (I love NY), (The City that Never Sleep), Филадельфия (The Place that Loves You Back), Такома (America's №1 Wired City), Грек (Live Your Myth in Greece) зэрэг улсууд адил сурталчилгааны уриаг **“Your Gate to Nomad Land”** буюу “Нүүдэлчдийн нутагт айлчлах Таны хаалга” гэдгээр төсөөлж Нисэхийн буюу Буянт ухаагийн цагаан хаалгыг бэлэг тэмдэг болгох нь зүйтэй юм.

2.6. ХҮҮХЭД, ЗАЛУУСЫН АЯЛАЛ

Сүүлийн үед төрийн бус байгууллага, хотын захиргааны санаачилга, нийгмийн хариуцлагатай зарим нэг компанийн санхүүгийн дэмжлэгтэй байгалийн, адал явдалт, хотын аяллыг зохион байгуулах ажил эрчимжиж ирсэн ч нийтийг бүрэн хамарч чадахгүй байна. Аяллын зарим компани, сургуулийн захиргаа, багш, эцэг эхийн зөвлөлийн санаачилгаар аялал зохион байгуулж байгаа ч улирлын шинжтэй, давталт бага, аюулгүй байдлын түвшин сул байна. ЕБС-ийн сурагчдын зохион байгуулалттай аяллын 40 орчим хувь нь хот дотор, 20 орчим хувь нь Манзушир, Цонжин болдог, Мэлхий хад зэрэг чиглэлд үлдсэн 30 орчим хувь ногоон бүс, голын эрэг хөвөөгөөр аялаж байна. Үүний зэрэгцээ зуны амралтаар хороо, дүүрэг орчмын ойрын зайн гол, ой, уулын зугаалга зэрэг зохион байгуулалтгүй аялал эрс нэмэгдэж байна. Түүнчлэн нисэх онгоцны загвар бүтээгч, адал явдалт спорт аялал, экологийн аялал зэрэг тусгай сонирхлын аяллууд өргөн зохион байгуулагдаж байгаа ч санхүүгийн боломжгүй байдлаас цөөн хэсгийг хамарч байна. Хотын хүн амын экологийн таагүй нөлөөллөөс гарч зуны зусланд гарах сонирхол өндөр болсон нь нийгэмд амралтын хэрэгцээ эрс нэмэгдэж байгааг илтгэж байна.

Хүүхдийн амралт, аялал нь үндэсний аялал жуулчлалд голлох байр суурийг эзэлдэг ч нийгмийн аялал жуулчлал учраас зах зээлийн харилцааны гадуур байж, төр захиргаанаас ихээхэн дэмжлэг шаарддаг. Улаанбаатарын бүсийн хүүхдийн амралт, аяллын үндсэн хэлбэр нь гэр бүлийн зуны зуслан, хүүхдийн зуны зуслан, хотын тойрон аялал, чөлөөт цагийн үзвэр үйлчилгээ, хөдөөгийн амралт байсаар байна. Хотын хүн ам өсөхийн хирээр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын тоо нэмэгдэж байгаа нь хүүхдийн амралт, аялал жуулчлалын төрийн бодлого зохицуулалт үгүйлэгдэж байна. Улаанбаатар хот орчимд 5554 ор бүхий 24 хүүхдийн зуслан үйл ажиллагаа явуулж зундаа 12000 орчим хүүхдэд хүлээн авч байгаа нь Улаанбаатар хотын 2009-2010 оны хичээлийн жил ЕБС-д суралцаж байгаа хүүхдийн 6.5 хувийг хамарч байна. Гэтэл



насанд хүрэгчдэд зориулсан амралт, аялал жуулчлалын зориулалттай 32000 ортой 1400¹⁸ байр сууц бүртгэгджээ. Түүнчлэн гадаад хэлний сургалттай хүүхдийн зуслан нэмэгдэх эхлэлүүд гарч байгаа бол уламжлалт хүүхдийн хөдөлмөр зуслан мартагдаад байна. Сүүлийн үед Хандгайт, Горхи, Бэлх, Найрамдал зэрэг хүүхдийн зуслан төвлөрсөн бүсүүд суурьшлын бүстэй холилдох болов. Зуслангийн бүс нь суурьшилын бүстэй холилдсон учраас Бэлх, Сэлбэ голын ай савын хүүхдийн зуны амралтын зуслангийн ажил үйлчилгээний нийгэм, хүмүүжлийн ач холбогдол алдагдах болов. Байгалийн амралт, экологийн хүмүүжил олгох уламжлалт зуны амралтын зусланг тусгай статус бүхий бүсийн эрх зүйн зохицуулалт шаардагдаж байна.

Хотын хүн амын амралт чөлөөт цагийг таатай өнгөрүүлэх үзвэр, үйлчилгээ, танин мэдэхүйн байгууламж, цогцолборын бүтээн байгуулалт удааширалтай байна. Хүүхдийн парк, хэдэн цэцэрлэгт хүрээлэн, хүн ойртоход аюултай дүүргийн өндөрлөгүүдээр нийтийн амралт, зугаалгын дэд бүтэц хязгаарлагдаж байна. Дэлхий даяар Уолт Диснейн амжилтын дараа Great Adventure, Lion Country Safari, Six Flags over Texas, Lotte World Adventure, Диснейленд Парис зэрэг амралт, зугаацлын паркийн цогцолборууд дэлхий даяар маш эрчимтэй байгуулагдах болов. Өнөөдөр нийслэлдээ амьтны хүрээлэнгүй улс цөөхөн байдаг байх. Иймээс амралт, зугаалга, зугаацал, адал явдлын паркийн цогцолбор байгуулах нь хотын нийтийн амралт, аялал жуулчлалын нэг чухал нөөц бүрдэх юм.

2.7. ӨМНӨХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Төлөвлөлт хийж байсан цаг үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал өнөө үеэс ялгаатай байсан ба амралт, аялал жуулчлалын бодлого чиглэл нь барьцгүй болж өгвөл тал бүрээр нь хөгжүүлэхийг эрмэлзэж байсантай холбогдон олон талыг асуудлыг тусгаж байсан учраас бодит хэрэгжилт үр дүндээ хүрээгүй байна. Улаанбаатарын бүсийн хөгжлийн 2006-2015 оны хөтөлбөрийн гүйцэтгэл тийм ч сайн хэрэгжээгүй байна.

Хүснэгт № 3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн 2006 – 2015 оны төлөвлөлтийн хэрэгжилтийн байдал

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжилт
1	Аялал жуулчлалын маршрутын дагуух зарим авто замыг сайжруулах зорилтыг дэд бүтцийн салбаруудын хөгжлийн хөтөлбөр, мастер төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх	Хэрэгжиж байгаа
2	Хотын ногоон бүс дэх аялал жуулчлалын төлөвлөлтийг сайжруулж, олон улсын түвшинд нийцсэн аялал жуулчлалын цогцолборууд бий болгохыг дэмжих	Хэрэгжилт тодорхойгүй
3	Аялал жуулчлалын маршрут дагуух түүх, соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх	Маршрут тодорхойгүй учраас хэрэгжилт дутуу
4	Улаанбаатар хотод олон улсын цанын баазыг байгуулж, өвлийн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх	Хэрэгжиж байгаа

¹⁸ 2009 оны аттестачилал. МХЕГ. 10500 ор бүхий 425 зочид буудал, 5000 ор бүхий 537 дэн буудал, 10400 ор бүхий 255 жуулчны бааз, 5900 ор бүхий 155 амралтын газар.



5	Аялал жуулчлалын бүс нутагт зочид буудал, зоогийн газар зэрэг үйлчилгээний газруудыг шинээр байгуулах	Хэрэгжилт тодорхойгүй
6	Хотын өнгө төрх, тохижилт, цэцэрлэгжилтэд онцгой анхаарч, сайжруулах	Хэрэгжиж байгаа
7	Горхи- Тэрэлж- Налайх- Тоньюкукийн хөшөө – Зуунмод-Манзуширийн хийд гэсэн маршрутын дагуу байгалийн болон түүх, соёлын аялал жуулчлалыг одоо байгаа материаллаг баазыг түшиглэн өргөтгөн хөгжүүлэх	Хэрэгжээгүй
8	Их тэнгэрийн ам, Бэлхийн ам, Гацууртын ам, Нүхтийн амны чиглэлээр аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх	Хэрэгжээгүй
9	Баянзүрх дүүргийн Гацуурт орчмын бүсийг аялал жуулчлал, амралт сувиллын бүс нутаг болгон хөгжүүлэх	Хэрэгжээгүй
10	Налайх дүүргийн Тэрэлж, Ар, Өвөр Жанчивланг амралт, аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлэх	Хэрэгжээгүй
11	Багануур, Налайх дүүргийг аялал жуулчлалын томоохон төв болгон хөгжүүлэх	Хэрэгжээгүй
12	Сонгино хайрхан дүүрэгт морин спорт, сургалт, аялал жуулчлалын төв, Зайсан толгойд соёл амралтын төвийг байгуулах	Дутуу
13	Монголын түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгэсэн хүмүүс, томоохон үйл явдлыг илэрхийлсэн дурсгалын цогцолборуудыг барьж байгуулах	Хэрэгжиж байгаа
14	Нүүдэлчин ард түмний амьдрал, соёл, уламжлал, олон ястны онцлогийг өвөрмөц байдлаар харуулсан нүүдэлчний хотхон байгуулах	Хэрэгжиж байгаа
15	Жуулчдын олноор хүрэлцэн очдог, чөлөөт цагаа өнгөрүүлдэг газруудад мэдээллийн самбар, тэмдэг, тэмдэглэгээг англи хэл дээр хийж байрлуулах	Хэрэгжилт тодорхойгүй
16	Тасганы овоонд Монголын Түүхийн үзмэр болон шашны үйлчилгээний төв цогцолбор байгуулах	Эхлэл төдий
17	Улаанбаатар хотыг Монгол улсын хот суурин газрын аялал жуулчлалын томоохон төв болгон хөгжүүлэх	Хэрэгжээгүй
18	Улаанбаатарын бүсийн талаархи мэдээлэл агуулсан “Газарчин” мэдээллийн сан, аяллыг зохион байгуулах зорилготой “Төлөвлөлт болон захиалга” мэдээллийн сан, хотод болж байгаа арга хэмжээ, үзвэр үйлчилгээний болон бусад арга хэмжээнүүдийг тусгасан “Улаанбаатар өнөөдөр” мэдээллийн сан бүрдүүлж интернэтэд ВЭБ хуудас нээн ажиллуулах	Хэрэгжиж байгаа
19	Улаанбаатар хоттой хамтын ажиллагаа бүхий бусад улсын хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллах	Хэрэгжилт тодорхойгүй
20	Бүсийн хэмжээнд аялал жуулчлалын, амралт-сувилгааны зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, иргэдийн оролцоог дэмжих	Хэрэгжилт тодорхойгүй
21	Аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор тэдгээрийн ажилтнуудыг төрөлжсөн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж байх	Хэрэгжилт тодорхойгүй
22	Аялал жуулчлалын эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг татвар, зээлийн бодлогоор оновчтой дэмжих	Хэрэгжилт тодорхойгүй
23	Түүх, соёлын уламжлалт ахуй амьдрал, соёл урлагийн чиглэлийн цэнгээнээс эхлэн бизнесийн арга хэмжээ, хурал цуглаан, уулзалт, зөвлөлгөөн зэрэг аялал жуулчлалын холбогдолтой бүх хэлбэрийн үйл ажиллагааг идэвхижүүлэх	Хэрэгжилт тодорхойгүй



24	Хүрээлэн байгаа орчинд аялал жуулчлалын үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж, аялал жуулчлалыг байгаль хамгаалах нэг арга хэрэгсэл болгох	Хэрэгжилт тодорхойгүй
25	Зочид буудлын ангиллын төрлүүд болох motel, гэст хаус, дэн буудлын үйлчилгээнд мөрдөх стандарт, эрх зүйн бусад баримт бичгийг гаргаж, ажил, үйлчилгээнд мөрдүүлэх	Эхлэл төдий
26	Аялал жуулчлалын бүх бааз, төвүүдийг дэлхийн түвшинд хүрсэн чанартай үйлчилгээтэй болгох	Хэрэгжээгүй
27	Эдийн засгийн хөшүүргүүд хэрэглэх замаар аялал жуулчлалын цөм бүс нутгуудад өндөр зэрэглэлийн тохилог зочид буудлууд барихыг дэмжих	Эхлэл төдий
28	Ази европын орнуудад сурталчлах замаар Улаанбаатарын бүс нутгийг олон улсын аялал жуулчлалын сүлжээнд хамруулах	Хэрэгжилт тодорхойгүй
29	Улаанбаатарын бүсийн олон ястны соёл урлаг, ардын өв уламжлалыг харгалзан дүүргүүдэд соёл урлагийн болон спортын төв, цогцолбор байгууламжуудыг барих	Хэрэгжилт тодорхойгүй
30	Улаанбаатарын бүсийг бусад бүсүүдийн аялал жуулчлалын төвүүдтэй оновчтой холбогдсон үндэсний хэмжээний аялал жуулчлалын томоохон төв болгох	Хэрэгжилт тодорхойгүй



3. АМРАЛТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН 2021-2030 ОНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

2020 оны түвшинд Улаанбаатарыг чиглэсэн ажил хэргийн аяллын урсгал жилийн дөрвөн улиралд, соёл-танин мэдэхүйн дундаж зардалтай аяллын урсгал зуны улиралд, хотын тойрон аялал жигдэрч, Горхи тэрэлжийн экологийн аялал зах зээлд гарч, Багануур, Чойр, Сайншанд, Өмнөговийн хотруу чиглэсэн амралт, аяллын урсгалууд бий болсон байхаар төсөөлөгдөж байна.

Хотын оршин суугчдын авто аялал, байгалийн аялалд оролцох нь нэмэгдэж байгаа нь тэдэнд болон гийчдэд зориулсан хотын зохион байгуулалттай аялал, байгалийн амралт, аялалтай холбоотой дэд бүтцийг улам боловсронгуй болгох болно.

Олон улсын жуулчлалын люкс сегментийг татах, иргэдийн гадаадад аялах болон гадаадаас жуулчин авах урсгалыг тэнцвэржүүлэх, дундаж үнэтэй буудлын нийлүүлэлтийг дэмжих, визийн горимыг зөөллөх, үндэсний соёл, урлаг, зан үйл, спортын амралт, аяллын үзвэр, үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулах, экологийн аяллыг түгээн дэлгэрүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаа чиглэгдэх болно. Хот, дүүргүүдэд спорт цогцолбор байгуулснаар нийтийн биеийн тамир, мэргэжлийн спортыг даган спортын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх боломж харагдаж байна.

Монголчуудын гадаад аяллын урсгалын дийлэнх хувийг арилжааны, эрүүл мэндийн, боловсролын аялал эзэлж, улмаар үндэсний аялал жуулчлалын төлбөрийн тэнцэлийн алдагдлыг бууруулах зарим арга замыг энэхүү төлөвлөгөөнд тусгав. Үндэсний аялал жуулчлалын тэнцвэртэй байдлыг хадгалахад Замын үүд, Алтанбулаг, Цагаан нуурын эдийн засгийн чөлөөт бүсэд импортын агуулах түшиглэн дотоодын арилжааны аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж бүрдэх болно.

Монгол улс дэлхийн уул уурхайн зах зээл нэг тоглогч болж байгаа нь зүүн хойд азийн ажил хэргийн аяллын өсөлттэй давхцаж байна. Энэ нь шинэ боломж, орлогын шинэ эх үүсвэр юм. Уул уурхай, аж үйлвэрийн цогцолборуудын бүтээн байгуулалт, шинэ суурингууд нь дотоодын амралт, сувилал, аяллын шинэ давалгаа, шинэ зах зээлийг үүсгэх магадлал өндөр байна. Товчоор монголын амралт, аялал жуулчлалын зангилаа бүс бий болж, олон улсын зах зээлд хандсан соёлын аялал жуулчлалын шинэ давалгаа эхлэнэ хэмээн төсөөлж байна.

Эдгээр хандлагад тулгуурлан Улаанбаатар хот, Нийслэлийн бүс, хотын нийгэм, эдийн засгийн эрчимтэй харилцааны орон зайн амралт, аялал жуулчлалын хөгжлийг чиг хандлагыг дагасан хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой төслөөр томъёолов.



3.1. УЛААНБААТАР ХОТОД

Дугаар: 2021-2030/01

Монголын их хаадын музей, 2023 оноос	
Ажил, үйлчилгээ	“Маршал Чойбалсангийн байр”-ыг сэргээн засварлаж, музейн үйлчилгээ үзүүлэх
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Барилга, гадна тохижилт, зам, мухлаг, ариун цэврийн газар, суурь дэд бүтэц, медиа хангамж, үзмэр цуглуулах зэрэг ажилд нийт 35500.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, БШУЯ, НЗДТГ, Холбогдох агентлаг, Төрийн бус байгууллага, хувийн хэвшил
Эрх зүйн зохицуулалт	Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. ¹⁹
Үр дүн	Бичил музейн нэгдсэн сүлжээний зохион байгуулалтаар түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сайжирна. Соёлын өв, дурсгалт зүйлсийг эдийн засгийн эргэлтэд оруулж, 30 байнгын ажлын байр бий болно.

Дугаар: 2021-2030/02

Занабазарын музей, 2024 оноос	
Ажил, үйлчилгээ	“Чин ван Ханддоржийн өргөө”-г сэргээн засварлаж, музейн үйлчилгээ үзүүлэх
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Барилга, гадна тохижилт, зам, мухлаг, ариун цэврийн газар, суурь дэд бүтэц, медиа хангамж, үзмэр цуглуулах зэрэг ажилд нийт 8000.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, БШУЯ, НЗДТГ, Холбогдох агентлаг, Төрийн бус байгууллага, хувийн хэвшил
Эрх зүйн зохицуулалт	Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. ²⁰ Тогтвортой амжиргаа төслөөр хэрэгжүүлнэ.
Үр дүн	Бичил музейн нэгдсэн сүлжээний зохион байгуулалтаар түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сайжирч байнгын 10 ажлын байр бий болно. Соёлын өв, дурсгалт зүйлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, сургалт, судалгааны түвшин нэмэгдэнэ.

¹⁹Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 10.1.

²⁰Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 10.1.



Дугаар: 2021-2030/03

Үлэг гүрээлийн музей, 2025-2029 он	
Ажил, үйлчилгээ	“Хүүхдийн урлан бүтээх төв”-г сэргээн засварлаж ашиглана.
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Барилга, гадна тохижилт, зам, мухлаг, ариун цэврийн газар, медиа хангамж, үзмэр цуглуулах зэрэг ажилд нийт 55500.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, БШУЯ, НЗДТГ, Холбогдох агентлаг, Төрийн бус байгууллага
Эрх зүйн зохицуулалт	Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. ²¹
Үр дүн	Бичил музейн нэгдсэн сүлжээний зохион байгуулалтаар түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сайжирч 30 байнгын ажлын байр бий болно. Соёлын өв, дурсгалт зүйлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, сургалт, судалгааны түвшин нэмэгдэнэ.

Дугаар: 2021-2030/04

Хотын нүүдлийн түүхийн музей, 2025 оноос	
Ажил, үйлчилгээ	Улаанбаатар хотын музейг сэргээн засварлаж Улаанбаатар хот байгуулахаас өмнөх түүхэн цаг хугацааны түүхэн замналыг илэрхийлсэн музейн үйлчилгээ үзүүлнэ.
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Барилга, гадна тохижилт, мухлаг, ариун цэврийн газар, суурь дэд бүтэц, медиа хангамж, үзмэр цуглуулах зэрэг ажилд нийт 10000.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, БШУЯ, НЗДТГ, Холбогдох агентлаг, Төрийн бус байгууллага, хувийн хэвшил
Эрх зүйн зохицуулалт	Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. ²² Тогтвортой амжиргаа төслөөр ВОО ²³
Үр дүн	Бичил музейн нэгдсэн сүлжээний зохион байгуулалтаар түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сайжирч 8 байнгын ажлын байр бий болно. Соёлын өв, дурсгалыг эдийн засгийн эргэлтэд оруулж, сургалт, судалгааны түвшин нэмэгдэнэ.

²¹Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 10.1.

²²Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 10.1.

²³Өөрөө барьж ашиглах. Build Own Operate



Дугаар: 2021-2030/05

Хүрээний худалдааны музей, 2025 оноос	
Ажил, үйлчилгээ	Богд хааны орос хөгжимчдийн байрыг сэргээн засварлаж, музейн үйлчилгээ үзүүлнэ.
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Барилга, гадна тохижилт, зам, мухлаг, ариун цэврийн газар, суурь дэд бүтэц, медиа хангамж, үзмэр цуглуулах зэрэг ажилд нийт 8500.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, БШУЯ, НЗДТГ, Холбогдох агентлаг, Төрийн бус байгууллага, хувийн хэвшил
Эрх зүйн зохицуулалт	Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. ²⁴ Тогтвортой амжиргаа төслөөр ВОО ²⁵
Үр дүн	Бичил музейн нэгдсэн сүлжээний зохион байгуулалтаар түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сайжирч 10 байнгын ажлын байр бий болно. Соёлын өв, дурсгалыг эдийн засгийн эргэлтэд оруулж, сургалт, судалгааны түвшин нэмэгдэнэ.

Дугаар: 2021-2030/06

Маршал, генералуудын музей, 2026 оноос	
Ажил, үйлчилгээ	Дэмид жанжины байрыг сэргээн засварлаж, музейн үйлчилгээ үзүүлнэ.
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Барилга, гадна тохижилт, зам, мухлаг, ариун цэврийн газар, суурь дэд бүтэц, медиа хангамж, үзмэр цуглуулах зэрэг ажилд нийт 6500.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, БШУЯ, НЗДТГ, Холбогдох агентлаг, Төрийн бус байгууллага, хувийн хэвшил
Эрх зүйн зохицуулалт	Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. ²⁶ Тогтвортой амжиргаа төслөөр ВОО ²⁷
Үр дүн	Бичил музейн нэгдсэн сүлжээний зохион байгуулалтаар түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сайжирч 10 байнгын ажлын байр бий болно. Соёлын өв, дурсгалыг эдийн засгийн эргэлтэд оруулж, сургалт, судалгааны түвшин нэмэгдэнэ.

²⁴Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 10.1.

²⁵Өөрөө барьж ашиглах. Build Own Operate

²⁶Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 10.1.

²⁷Өөрөө барьж ашиглах. Build Own Operate



Дугаар: 2021-2030/07

Оросын хаадын музей, 2027 оноос	
Ажил, үйлчилгээ	Барон Унгерны байшинг сэргээн засварлаж, музейн үйлчилгээ үзүүлнэ.
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Барилга, гадна тохижилт, зам, мухлаг, ариун цэврийн газар, суурь дэд бүтэц, медиа хангамж, үзмэр цуглуулах зэрэг ажилд нийт 2500.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, БШУЯ, НЗДТГ, ХОЛБОГДОХ АГЕНТЛАГ, Төрийн бус байгууллага, хувийн хэвшил
Эрх зүйн зохицуулалт	Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. ²⁸ Тогтвортой амжиргаа төслөөр ВОО ²⁹
Үр дүн	Бичил музейн нэгдсэн сүлжээний зохион байгуулалтаар түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжирч 10 байнгын ажлын байр бий болно. Соёлын өв, дурсгалыг эдийн засгийн эргэлтэд оруулж, сургалт, судалгааны түвшин нэмэгдэнэ.

Дугаар: 2021-2030/08

Усан паркийн ТЭЗҮ боловсруулах, 2025 оноос	
Ажил, үйлчилгээ	Усан гулгуур бүхий задгай усан сан, наран шарлагын талбай, спортын загасчлалын цөөрөм, загас үржүүлгийн цөөрөм, спортын битүү усан сан, завиар зугаалах цөөрөм, дагалдах үйлчилгээ бүхий байгууламж байна.
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	ТЭЗҮ ³⁰ боловсруулахад 200.0
Хэрэгжүүлэгч байгууллага	ССАЖЯ, Холбогдох агентлаг, НЗДТГ
Эрх зүйн зохицуулалт	ISO стандартыг баримтлан усан тоглоомын газрын стандарт батлуулах. Олон улсын усан сэлэлтийн холбооны (FINA) стандартын шаардлага хангсан усан зам байгуулах.
Үр дүн	Хүүхэд, залуусын амралт, зугаалгын шинэ орчин бүрдэнэ.

²⁸Соёлын өвийг хамгаалах тухай хууль. 10.1.

²⁹Өөрөө барьж ашиглах. Build Own Operate

³⁰1 га усан парк 2400.0-4000.0 сая ам.долл., 4-5 жилд өртөгөө нөхдөг.



Дугаар: 2021-2030/09

Туул голын усан боолтын амралтын цогцолборын ТЭЗҮ боловсруулах, 2025 оноос

Ажил, үйлчилгээ	Усан аялал, мөсөн гулгуур, нохой чарганы аялал, морин чарганы аялал, морин аялал, загасчлал, байр сууц, дагалдах бусад үйлчилгээ
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Хөрөнгө оруулалтын хэмжээг ТЭЗҮ-ээр тогтооно. ³¹ 200.0
Хэрэгжүүлэгч байгууллага	ССАЖЯ, Холбогдох агентлаг, НЗДТГ
Эрх зүйн зохицуулалт	Байгууламж, аяллын бүтээгдэхүүний ISO стандарттай болох
Үр дүн	Хүүхэд, залуусын амралт, зугаалгын шинэ орчин бүрдэнэ.

Дугаар: 2021-2030/10

Өндөр технологийн цэвэрлэх байгууламжийг дагалдах үйлчилгээ, 2025 оноос

Ажил, үйлчилгээ	Битүү усан сан, усанд орох газар, саун, БШУЯлдаржуулах клуб, тоглоомын задгай талбай, зуушны газар бүхий цогцолборыг суурьшилын цэвэрлэх байгууламжийн станцуудыг түшиглэн байгуулна.
Хөрөнгө оруулалтын хэмжээ, сая ₮	Хотын 1 төв, дэд 2 төв, бичил 23 төв нийт 26 цэвэрлэх станцын суурь дэд бүтэц, усны хангамжийг түшиглэнэ. Нийт 400000.0
Хэрэгжүүлэгч байгууллага	БХБЯ, ССАЖЯ, Холбогдох агентлаг, НЗДТГ, хувийн хэвшил, гадаадын хандив.
Эрх зүйн зохицуулалт	Байгууламж, аяллын бүтээгдэхүүний ISO стандартын дагуу концессийн гэрээний барих-үйл ажиллагаа явуулах-шилжүүлэх ³² загвараар төслийг хэрэгжүүлэх.
Үр дүн	Хотын ахуйн үйлчилгээ, амралт, чийрэгжилтийн шинэ орчин бүрдэнэ. 300 ажлын байр бий болно.

³¹Усан боолтын газар тодорхой болсон цагт эхлүүлнэ.

